



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Төвшрүүлэх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/03/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.03.23 № 138

танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Б.БЯМБАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогыг сумын төсөвт төвлөрүүлдэг болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 127 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 77.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	844,288.52	599,267.96
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	318,477.88	173,854.59
33	АВЛАГА	219,707.44	335,362.06
35	БАРАА МАТЕРИАЛ	274,139.21	67,622.31
36	НӨӨЦИЙН БАРАА	31,964.00	22,429.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	14,150,494.06	7,933,819.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,150,494.06	7,933,819.28
39200	Биет хөрөнгө	14,022,416.00	7,908,738.45
39300	Биет бус хөрөнгө	128,078.07	25,080.83
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,994,782.59	8,533,087.24
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,067.54	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,067.54	0.00
41300	Өглөг	2,067.54	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,992,715.04	8,533,087.24
51	Засгийн газрын хувь оролцоо	14,992,715.04	8,533,087.24
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,960,265.70	656,071.52
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	656,071.52
51200	Хуримтлагдсан үр дүн	10,487,918.73	7,748,655.78
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,544,530.61	128,359.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,994,782.59	8,533,087.24

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	9,996,097.01	1,306,210.14
11	ТАТВАРЫН ОРЛОГО	93,690.89	458,250.83
110	Орлогын албан татвар	42,167.73	195,308.23
1100	Хувь хүний орлогын албан татвар	42,167.73	195,308.23
113	Хөрөнгийн албан татвар	21,788.66	42,602.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,734.50	220,340.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,326,674.90	251,370.42
120	Нийтлэг татварын бус орлого	7,326,674.90	251,370.42
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,575,731.22	596,588.89
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,042,483.93	1,545,116.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,042,483.93	1,545,116.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,943,166.36	1,420,827.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,720,355.67	382,016.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,945.10	47,803.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	121,030.33	130,012.84
2104	Хангамж, бараа материалын зардал	70,164.20	41,863.35
2105	Нормативт зардал	367,055.07	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,956.16	28,513.90
2107	Томилолт, зочны зардал	2,132.70	2,690.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,131.48	33,368.13
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	384,395.65	754,559.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,317.57	124,906.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,953,613.07	(328,906.39)

V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	106,775.51	6,122,548.46
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	6,846,837.57	(6,361,454.86)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,830,755.44	1,168,801.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	93,690.89	458,250.83
110	Орлогын албан татвар	42,167.73	195,308.23
1100	Хувь хүний орлогын албан татвар	42,167.73	195,308.23
113	Хөрөнгийн албан татвар	21,788.66	42,602.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	29,734.50	220,340.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,751.95	5,837.86
1181	Газрын төлбөр	5,822.13	199,180.93
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,160.43	15,321.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	241,904.23	113,961.48
120	Нийтлэг татварын бус орлого	241,904.23	113,961.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,495,160.32	596,588.89
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,534,430.94	870,025.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,534,430.94	870,025.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,435,092.11	743,756.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,719,338.59	382,016.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	219,138.11	47,803.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,628.15	128,912.84
2104	Хангамж, бараа материалын зардал	61,339.98	33,377.78
2105	Нормативт зардал	187,963.05	800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,929.50	34,261.90
2107	Томилолт, зочны зардал	2,132.70	2,490.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,045.25	38,767.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,576.78	75,326.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,338.82	126,269.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	296,324.50	298,775.87
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	120,164.43	178,455.36
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	120,164.43	178,455.36
2200	Дотоод эх үүсвэрээр	120,164.43	178,455.36
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-120,164.43	-178,455.36
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	-264,943.80
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	264,943.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	176,160.07	-144,623.29
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	142,317.81	318,477.88
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	318,477.88	173,854.59

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,145,877.47	8,145,877.47
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,145,877.47	8,145,877.47
9	Тайлант үеийн үр дүн	6,846,837.57	6,846,837.57
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	14,992,715.04	14,992,715.04
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	14,992,715.04	14,992,715.04
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(98,172.94)	(98,172.94)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	14,894,542.10	14,894,542.10
19	Тайлант үеийн үр дүн	(6,361,454.86)	(6,361,454.86)
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,533,087.24	8,533,087.24

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,353,901.20	1,270,208.34	83,692.86	93.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	890,862.50	834,823.03	56,039.47	93.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	787,581.00	731,541.53	56,039.47	92.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	399,396.30	382,016.40	17,379.91	95.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,549.30	47,803.61	2,745.69	94.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,566.20	128,912.84	8,653.36	93.71
2104	Хангамж, бараа материалын зардал	35,110.50	32,916.38	2,194.12	93.75
2105	Нормативт зардал	800.00	800.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,261.90	34,261.90	1,000.00	97.16
2107	Томилолт, зочны зардал	2,500.00	2,490.00	10.00	99.60
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,386.20	27,713.83	1,672.37	94.31
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	97,010.60	74,626.58	22,384.02	76.93
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	103,281.50	103,281.50	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	103,281.50	103,281.50	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	198,094.90	170,441.51	27,653.39	86.04
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	264,943.80	264,943.80	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,353,901.20	1,065,079.34	288,821.86	78.67

Архангай аймгийн Төвшрүүлэх сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,003,449.20	962,151.64	41,297.56	95.88
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	350,452.00	102,927.70	247,524.30	29.37
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	122.00	122.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	60.00	60.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	39.00	39.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	60.00	60.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,691.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,691.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,214.68
2104	Хангамж, бараа материалын зардал	461.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,053.28
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,477.05
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,477.05
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,621.73
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	32,621.73
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-70.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй, залруулагдаагүй нийт **95,814.7** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчил арилгуулах 95,814.7 мянган төгрөгийн 3 албан шаардлага, төсвийн төлөвлөлттэй холбоотой 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Албан шаардлага

5.1.1 Хоршоо хөгжүүлэх санд 22 зээлдэгчтэй холбоотой 56122.4 мянган төгрөгийн 1-7 жилийн насжилттай хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.1.2 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 7 нэр төрлийн орлого 39,692.3 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1 “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар”, 23.8.14 “Газрын төлбөр”, 31 дүгээр зүйлийн 31.4.1-т “төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо”, 31.4.5 “Төсвийн гүйцэтгэлийн дүн шинжилгээний тайлан болон тухайн жилийн төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлийн урьдчилсан тооцоо”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.1.3 Хоршоо хөгжүүлэх сангаас тайлант онд тус сангаас зээл хүсэгч, ЖДҮҮЭ-чдээс заавал бүрдүүлэх материалуудыг бүрэн бүрдүүлж авалгүйгээр төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 7 ААНБ, хоршоонд нийт 265,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Мөн шаардлага хангаагүй 3 ААНБ, хоршоонд зээл олгосны дотор “Мөнх тайгын ургац” ХХК нь 2021.11.30-ны өдөр газар тариалан, модон эдлэл үйлдвэрлэл, худалдаа, барилгын материалын худалдаа, тавилга үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар хуулийн этгээдийн гэрчилгээ авч, байгуулагдснаас хойш огт үйл ажиллагаа явуулаагүй байхад тус байгууллагын үндсэн чиглэлд хамааралгүй “Үхрийн фермерийн аж ахуй эрхлэн сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх” төсөлд 45,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 5 дугаар зүйлийн 5.5 “Хоршоо, ЖДҮҮЭ нь төсөлд дараах материалуудыг хавсаргасан байна: 5.5.6. хуулийн этгээдийн хаягийн тодорхойлолт, үүсгэн байгуулагчийн лавлагаа, 5.5.9. сүүлийн 3 жилийн санхүүгийн баталгаажсан тайлан, 5.5.11. Нийгмийн даатгалд хамруулсан ажилтны тоо, төлж байгаа шимтгэлийн хэмжээ болон нийгмийн лаатгалын байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт, 5.5.12. төлбөртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдээгүй талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт”, 6 дугаар зүйлийн 6.3. Сангаас

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зээл авч, төсөл хэрэгжүүлэх хоршоо, ЖДҮҮЭ нь дараах шаардлагыг хангасан байна: 6.3.1. тухайн суманд бүртгэлтэй, 3-р доошгүй жил тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байх, 6.3.2. Монгол банкны зээлийг мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх, 6.3.3. зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх, 6.3.5... ЖДҮҮ-г дэмжих тухай хуулийн 6.1-д заасан байгууллагад бүргүүлж тодорхойлолт авсан аж ахуй нэгж байх, 6.3.6. гурваас доошгүй жил идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж, санхүүгийн тайлангаар баталгаажсан байх, 6.4.6. ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.1.4. Шилэн дансны цахим системд 16 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тус сум нь 2022 оны төсвийн төслийг боловсруулахдаа цалин хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого, галт зэвсгийн албан татвар, ан амьтны нөөц ашигласны төлбөр, газрын дуудлага худалдааны төлбөр, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг нэр төрлөөр нь огт төлөвлөөгүй, бусад орлогын нэр төрлийг хэт багаар төсөвлөсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1 "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар", 8.2 "галт зэвсгийн албан татвар", 8.4 "агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж", 23.8.14 "Газрын төлбөр", 23.8.16 "үл хөдлөх хөрөнгийн албан татвар", Сангийн сайдын 2011 оны 244 дүгээр тушаалын хавсралт "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 7 дугаар зүйлийн 7.6 "Сум, дүүргийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана", 7.6.1 "сум, дүүргийн Засаг дарга өөрийн төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын тухайн жилд олох орлогын хэмжээг дараахь байдлаар тооцох", 7.6.1а/ "сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2011 оны 244 дүгээр тушаалын хавсралт "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ыг мөрдөж, холбогдох тооцоо судалгаанд үндэслэн төсвийг бодиттой төлөвлөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төвшрүүлэх сумын ТТЗ	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төвшрүүлэх сумын ТТЗ	4	95,814.7	0	0	3	95,814.7	1	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Төвшрүүлэх сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0	0	0	0	